

**ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН ЦАХИМ СИСТЕМ, СУУРЬ СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ГАНЗОРИГИЙН ЗОЛЗАЯАГИЙН 2024 ОНЫ
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)**

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Газрын мониторингийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг арга хэмжээ хэрэгжүүлэх	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээн ий багийн хянан баталгаа жуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх.					
1.	Арга хэмжээ 1.1 Газрын мониторингийн цахим системд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтэд тусгагддаг газрыг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр холбогдох хууль, журамд тодорхой заасан заалт болон нийтлэг зөвлөмж, арга хэмжээний загварыг жагсаалтаар бэлтгэж, системээс автоматаар сонгогдох боломжийг бүрдүүлэх.	60	5	65	
2.	Арга хэмжээ 1.2 Улсын тусгай хэрэгцээ, ойн сан бүхий, усны сан бүхий газрын мониторингийн цэгийн байршил, байнгын ажиглалтын талбаруудын төлөөлөх талбайн хэмжээ, байршлыг нарийвчлан зураглах талаар санал боловсруулах.	55	10	65	
Зорилт 2. Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих					
1.	Арга хэмжээ 2.1 Ойн сан бүхий болон усны сан бүхий газрын хамгаалалт, эрүүл ахуй, хориглолтын бүсийг холбогдох байгууллагуудтай хамтран зураглах, газрын мониторингийн цахим системийн дундын мэдээллийн сантай холбох.	50	3	55	
2.	Арга хэмжээ 2.2 Улсын хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөт хянан баталгааны ажил болон	50	10	60	

	захиалгат хянан баталгааны ажлын үр дүн, мэдээллийг нэгтгэж, газрын мониторингийн цахим системд нөхөж оруулах.				
Зорилт 3. Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг нэвтрүүлэх.					
1.	Арга хэмжээ 3.1. Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох.	50	10	60	
2.	Арга хэмжээ 3.2. Газрын мониторингийн цахим системд зайнаас тандан судлал, доройтлыг тодорхойлох зураглалыг үүсгэх шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийх.	50	10	60	
3.	Арга хэмжээ 3.3. Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, салбар хоорондын мэдээллийг холбох ажлыг зохион байгуулах.	45	5	50	
4.	Арга хэмжээ 3.4. Газрын мониторингийн цахим системийн хялбарчилсан цахим гарын авлага гаргах.	45	5	50	
5.	Арга хэмжээ 3.5. Газрын мониторингийн суурь мэдээлэл болох хүрээлэн буй орчин, инженер геологи, газар хөдлөлт, гамшгийн мэдээллийн санг баяжуулах талаар санал боловсруулах.	55	5	60	
Зорилт 4. Улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх.					
1.	Арга хэмжээ 4.1. Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх.	60	10	70	
2.	Арга хэмжээ 4.2. Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх.	60	10	70	
Зорилт 5. Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох.					
1.	Арга хэмжээ 5.1. Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах	50	10	60	
Зорилт 6. Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах.					
1.	Арга хэмжээ 6.1. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж, цахимаар болон хэвлэмэл байдлаар	60	10	70	

	ирүүлсэн тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах.				
2.	Арга хэмжээ 6.2. Магадлан итгэмжлэгдсэн хөрсний хяналт, шинжилгээний лабораторид хийгдсэн хөрсний задлан шинжилгээний хариуг Газрын мониторингийн цахим системд автоматаар оруулах ажлыг зохион байгуулах	60	10	70	
Зорилт 7. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх.					
1.	Арга хэмжээ 7.1. Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах.	60	10	70	
2.	Арга хэмжээ 7.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх.	60	10	70	
3.	Арга хэмжээ 7.3. Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах.	—			
4.	Арга хэмжээ 7.4. Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах.	60	10	70	
5.	Арга хэмжээ 7.5. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх.	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Баруун бүсийн 5 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	60	10	70	
2.	"Хөрс, ус, агаар орчны судалгаа-GLOBE 2024" илтгэлийн уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн 9-12 ангийн сурагчдын дунд зохион байгуулах	60	10	70	
3.	"2022 оны 22/265 тоот гэрээт ажлын баталгаат хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө"-г боловсруулах	60	10	70	
4.	Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран ажиллах гэрээ боловсруулж батлуулах, мэргэжилтэнд эрх нээх тушаал боловсруулж батлуулах	60	10	70	
5.	"FASEP-MONGOLIA" төслийн явц үр дүнг танилцуулах сургалт, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	60	10	70	
6.	Говийн бүсийн 5 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	60	10	70	
7.	Зүүн бүсийн 3 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	60	10	70	
8.	21 аймгийн ГХБХБГ-ын суурь судалгаа мониторинг хариуцсан мэргэжилтэн, нийслэл дүүргийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн сургалт	60	10	70	
Дундаж оноо:				65.5	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Удирдлагын академийн "Өгөгдлийн сан", "Өгөгдлийн график дүрслэл" цахим сургалт	100%	15	
2.	Арга хэмжээ 2. Төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалт /Монгол бичиг/	100%	15	
3.	Арга хэмжээ 3. "Цаг агаарын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ" сэдэвт сургалт	100%	15	
4.	Арга хэмжээ 4. "Шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих аргачлал боловсруулах нь" сэдэвт сургалт	100%	15	
Дундаж оноо			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		6.8	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 65.5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 6.8

4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		95.9

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Газрын мониторингийн
хэлтсийн дарга



/ Б.Дөл /

2024.12.04 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Газрын мониторингийн
цахим систем, суурь
судалгаа, мэдээлэл
хариуцсан мэргэжилтэн




/ Г.Золзаяа /
2024.12.04 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч

ТЗУГ-ын дарга



/ Б.Анхбаяр /
2024.12.19 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ТЗУГ-ын ахлах урьтчилсан




/ С.Ганцмүр - 2 /
2024.12.19 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Газар зохион байгуулалт,
геодези, зураг зүйн ерөнхий
газрын дарга



/ А.ЭНХМАНЛАЙ /
2024.12.20 (огноо)

ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН ХЭЛТСИЙН ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН ЦАХИМ СИСТЕМ,
СУУРЬ СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.ЗОЛЗАЯАГИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)					
	1	2	3	4	5			6	7	
Зорилт 1 “Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх.”										
1.	Арга хэмжээ 1.1 Газрын мониторингийн цахим системд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтэд тусгагддаг газрыг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр холбогдох хууль, журамд тодорхой заасан заалт болон нийтлэг зөвлөмж, арга хэмжээний загварыг жагсаалтаар бэлтгэж, системээс автоматаар сонгогдох боломжийг бүрдүүлэх	Дүгнэлтийн загварт орох багц зөвлөмж, арга хэмжээний жагсаалт	-	Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгааны дүгнэлтэд тусгагдсан хөрсний эрүүл ахуйн дүн шинжилгээний мэдээллийг автоматаар татагдах боломжийг Газрын мониторингийн цахим системд бүрдүүлсэн байна. Ой, усан сангийн газар хийгдсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтэд тусгагдсан газар ашиглалтын зөрчлийн загварт орох зөвлөмжийн жагсаалт гаргаж хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Анхбаярт хүргүүлсэн.	Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгааны дүгнэлтэд тусгагдсан хөрсний эрүүл ахуйн дүн шинжилгээний мэдээлэлтэй холбоотой нийтлэг зөвлөмжийн жагсаалт гаргасан. Ой, усан сангийн газар хийгдсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтэд тусгагдсан газар ашиглалтын зөрчлийн загварт орох зөвлөмжийн жагсаалт гаргаж хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Анхбаярт хүргүүлсэн.			1-6 сар		

2	Арга хэмжээ 1.2 Улсын тусгай хэрэгцээ, ойн сан бүхий, усны сан бүхий газрын байршил, байнгын цэгийн байршил, байнгын ажиглалтын талбаруудын төлөөлөх талбайн хэмжээ, байршлыг нарийвчлан зураглах талаар санал боловсруулах	1 баримт бичгийн төсөл	-	Монгол Улсын байгаль-нутаг дэвсгэрийн нөхцөл, газрын нэгдмэл сангийн ойн сан бүхий газрын байнгын ажиглалтын талбар, мониторингийн цэгүүдэд дүн шинжилгээ хийсэн байна. Ойн сан бүхий газрын мониторингийн цэг болон байнгын ажиглалтын талбарын хэмжээг зураглаж, нарийвчлах талаар санал боловсруулж, зардлын хэмжээг гаргасан байна.	хийлгэхээр ажлын даалгаврын төсөл, танилцуулгыг бэлэн болгосон. 2023 оны нэгдмэл сангийн ангиллын мэдээнд ойн сан бүхий газар 18211,1 мянган га талбайг хамарч байна. Газрын мониторингийн мэдээллийн санд байгаа ойн сан бүхий газрын мониторингийн цэгүүдийг аймгуудын ойн сан бүхий газартай давхцуулан дүн шинжилгээ хийхэд Увс, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь аймаг ойн сан бүхий газрын мониторингийн хөрс, ургамлын тус бүр 1 цэгтэй, Говь-Алтай, Архангай, Дорнод, Сэлэнгэ, Өвөрхангай аймаг 3 цэгтэй, Завхан аймаг, Нийслэл 5 цэгтэй, Булган, Хөвсгөл аймаг 6 цэгтэй, Төв аймаг 7 цэгтэй, Хэнтий аймаг 17 цэгтэй байна. Ховд, Орхон, Баян-Өлгий, Дундговь, Сүхбаатар аймаг ойн сан бүхий газрын мониторингийн цэггүй байна. Улсын хэмжээнд ойн сан бүхий газарт нийтдээ 66 хөрс, ургамлын мониторингийн цэг байна. Энэхүү цэгүүдийг сонгохдоо байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн бүс бүслүүрийн ялгаа, ой модны төрөл, төлөв байдлын өөрчлөлт, газар ашиглалтыг харгалзан үзсэн байна. Үүнээс хойш ойн сан бүхий газрын талбайн хэмжээнд томоохон өөрчлөлт ороогүй тул цэг нэмж байгуулах шаардлагагүй байна.	1-12 сар	
---	--	------------------------------	---	--	---	----------	--

						Харин ажиглалтын талбарын судалгааг 5 жил тутамд хийж мониторингийн мэдээллийн санд оруулах шаардлагатай тул судалгааг Ойн газартай хамтран хийх нь зүйтэй байна.		
Зорилт 2 “Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих”								
3	Арга хэмжээ 2.1 Ойн сан бүхий болон усны сан бүхий газрын хамгаалалт, эрүүл ахуй, хориглолтын бүсийг холбогдох байгууллагуудтай хамтран зураглах, газрын мониторингийн цахим системийн дундын мэдээллийн сантай холбох.	Ой сан болон усны сангийн батлагдсан хамгаалалтын бүсийг цахим системд оруулсан байна.	-	Ойн газрын ойн мэдээллийн сангийн мэдээллийг газрын мониторингийн мэдээллийн сантай холбох ажлыг зохион байгуулсан байна.	Ой газрын ойн мэдээллийн сангийн мэдээллийг газрын мониторингийн мэдээллийн сантай холбох ажлыг зохион байгуулсан байна.	Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 107 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн БОАЖЯ-ны мэдээллийн сантай танилцах мэдээлэл солилцох боломжийг судлах уулзалтад оролцсон. Уулзалтын үр дүнд ойн мэдээллийн санг газрын мониторингийн мэдээллийн сантай холбох мэдээллийн жагсаалтанд оруулсан. Байгаль орчин аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/120 дугаар тушаалаар 6 байгууллагын 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Систем хөгжүүлэлтийн ажлыг 2024 оны 3 дугаар улиралд багтаан дуусгахаар төлөвлөөд байгаа бөгөөд энэхүү ажлын хүрээнд ойн мэдээллийн санг Газрын мониторингийн мэдээллийн сантай холбоно. Нийслэлийн байгаль орчны газрын ногоон бүсийн shr файлыг Нийслэлийн байгаль орчны газраас	1-9 сар	

					авсан боловч энэхүү бүс нь албажаагүй тул системд оруулаагүй. Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.2, 8.5.3 дахь хэсэгт заасан бүсийн батлагдсан тоон мэдээллийг ирүүлэх тухай 2/3304 дугаартай албан бичгийг Ойн газарт хүргүүлсэн.	
4	Арга хэмжээ 2.2 Улсын хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөт хянан баталгааны ажил болон хянан захиалгат ажил болон хянан баталгааны ажлын үр дүн, мэдээллийг нэгтгэж, газрын мониторингийн цахим системд нөхөж оруулах.	Судалгаа гарч, мэдээллийн сан бүрдсэн байна.	Архангай, Булган, Сэлэнгэ, Орхон, Хөвсгөл, Дундговь, Өмнөговь аймгийн 2010-2023 оны хооронд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газруудын тоон мэдээлэл, мөн захиалгат хянан баталгааны мэдээллийг газрын мониторингийн цахим системд оруулахад бэлэн болгосон байна.	Архангай, Булган, Сэлэнгэ, Орхон, Хөвсгөл, Дундговь, Өмнөговь аймгийн 2010-2023 оны хооронд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын захиалгат хянан баталгааны ажил болон төлөвлөгөөт хянан баталгааны ажлын мэдээллийг жагсаалтаар болон ажлын тайланг, тоон мэдээллийн хамт 2024 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх тухай 2024 оны 05 дугаар сарын 1/1336 дугаартай албан бичгийг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр албан бичгийг хүргүүлсэн. Хариуцсан 7 аймгийн мэдээллийг нэгтгэн захиалгат хянан баталгаа 108 нэгж талбарын 55520.93 га, төлөвлөгөөт хянан баталгаа нийт 515867.6 га талбайд 17 багц ажил хийгдсэн байна. Улсын хэмжээнд төлөвлөгөөт хянан баталгааны нийт 109 багц ажил байна. Газрын мониторингийн цахим системд оруулах төлөвлөгөө боловсруулан нэгжийн даргад танилцуулсан.	1-12 сар	

Зорилт 3 “Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг нэвтрүүлэх”

5	Арга хэмжээ 3.1 Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох.	5 аймгийн тайлан	1. Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 126 дугаар тушаалын хавсрлатаар "Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар" батлагдсан. 2. Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 172 дугаар тушаалын хавсрлатаар "Зайнаас тандан	Архангай, Булган, Сэлэнгэ, Орхон, Хөвсгөл аймгийн ГХБХБГ-ын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хиймэл дагуулын 6-9 дүгээр сарын мэдээнд үндэслэн нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн газрын биомассыг тооцох, бэлчээрийн даацыг тодорхойлж, дүн шинжилгээ хийхэд мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.	Хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн. 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор тайлан ирүүлэх тухай чиглэл өгч ажилласан. 5 аймгийн ирүүлсэн мэдээллийг нэгтгэн хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.	7-12 сар
---	---	------------------	--	--	---	----------

			судлалын аргаар тариалангийн газрын мониторинг хийх аргачилсан заавар" батлагдсан.				
6	Арга хэмжээ 3.2 Газрын мониторингийн цахим системд зайнаас тандан судлал, доройтлыг тодорхойлох зураглалыг үүсгэх шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийх	Нэмэлт модуль хөгжүүлсэн байдал		Газрын мониторингийн цахим системд газрын доройтлын зургийг зураглах, нэмэлт хөгжүүлэлт хийх, газрын удирдлагын нэгдсэн системийн хөгжүүлэлтийн ажлын даалгаварт тусгасан байна.	Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлтийн ажлын санал боловсруулж ОЗӨДБГ-ын орон зайн өгөгдлийн стандарт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ч.Чимэгбаярт хүргүүлсэн. Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлтийн ажлын даалгаварт тусгахад санхүүжилтын хувьд боломжгүй байгаа талаар хариу ирсэн байна.	1-12	
					Иймд "Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөл"-ийн хүрээнд "Бэлчээрийн фото мониторингийн цэг төлөөлөх талбайг нарийвчлан зураглаж, газрын мониторингийн цахим системд оруулах" ажлын хүрээнд мониторингийн цэг төлөөлөх талбайн хэмжээ, бэлчээрийн төлөв байдал нь доройтсон газрыг зураглаж, газрын мониторингийн цахим системийн нөхөн сэргээх, хамгаалах цэсрүү илгээх, оруулах байдлаар хөгжүүлэлт хийгдэж байна. Систем хөгжүүлэлтийн ажлын гүйцэтгэгчээр "Эрхэт инноваци" ХХК		

					шалгарсан бөгөөд систем хөгжүүлэлтийн ажил хийгдсэн. Тус ажлын хүрээнд бэлчээрийн фото мониторингийн сэргэх чадавхийн 3, 4, 5 дугаар түвшний цэгийн талбайг газрын хохирол, доройтол цэс рүү татах хөгжүүлэлтийг хийлгэж, үр дүнг хүлээн авсан. Бэлчээрийн фото мониторингийн гар утасны аппликэйшныг хэрэглээнд нэвтрүүлэх талаар туршилт судалгааг хийсэн. Аймгуудын мэргэжилтэн, даамлуудаас ирсэн саналыг нэгтгэн хөгжүүлэгчид хүргүүлсэн. Саналын дагуу хийгдсэн хөгжүүлэлтүүдийг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр танилцуулж, хүлээн авсан.	
7	Арга хэмжээ 3.3 Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, салбар хоорондын мэдээллийг холбох ажлыг зохион байгуулах	4 байгууллагын мэдээлэл (ҮСХ, АМГТГ, ХХААХҮЯ, БОАЖЯ)	Салбар дундын мэдээллийн санг холбох талаар ХХААХҮЯ, БОАЖЯ-тай хамтарсан уулзалт зохион байгуулах, мэдээллийг авах ажлыг зохион байгуулсан байна.	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн бэлчээрийн төлөв байдлын зураглалын 1513 цэгийн мэдээллийг шинэчлэн дундын мэдээллийн санд оруулахаар Хөдөө аж ахуйн цаг уурын судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Мэндбаяртай уулзаж, харилцан тохиролцсон. Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас тариалангийн газрын 300 мониторингийн цэгийн шинэчлэгдсэн 2023 оны мэдээллийг дундын мэдээллийн санд оруулахаар мэдээллийг авсан. ХХААХҮЯ-ны 300 цэгийн мэдээлэл, НБОГ-ын хөрсний шинжилгээний	1-12	

					2023 оны мэдээлэл, ЦУОШХ-ийн 1513 цэгийн 2022 оны мэдээллийг дундын мэдээллийн сангаар дамжуулан хэрэглээнд гаргасан.		
8	Арга хэмжээ 3.4 Газрын мониторингийн цахим системийн хялбарчилсан цахим гарын авлага гаргах.	1 гарын авлага			Орон нутгийн мэргэжилтэн болон мэргэжлийн байгууллагуудад зориулсан газрын мониторингийн цахим системийн цэс тус бүрийг агуулсан цахим гарын авлагыг гаргасан боловсруулж, байна.	Аймаг, нийслэлийн мэргэжилтнүүдэд зориулж Газрын мониторингийн цахим системийн цахим гарын авлагыг боловсруулсан. Хөгжүүлэлтийн ажил хийгдэж дуусаагүй байгаа зарим цэсийн хөгжүүлэлтийн ажил дуусахад гарын авлагыг эцэслэн боловсруулж, хэвлүүлнэ.	7-12
9	Арга хэмжээ 3.5 Газрын мониторингийн суурь мэдээлэл болох хүрээлэн буй орчин, инженер геологи, газар хөдлөлт, гамшгийн мэдээллийн санг баяжуулах талаар судалгаа хийсэн байна. Баяжуулах шаардлагатай суурь судалгааны мэдээллийн тооцоо, судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран баяжуулах ажлыг зохион байгуулах талаар санал боловсруулсан байна.	Судалгааг гаргаж, баяжуулах санал	Үндсэн 10 мэдээллийн сан, 75 сэдэвчилсэн тоон зураг.		Хүрээлэн буй орчин, инженер геологи, газар хөдлөлт, гамшгийн мэдээллийн санг баяжуулах талаар судалгаа хийсэн байна. Баяжуулах шаардлагатай суурь судалгааны мэдээллийн тооцоо, судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран баяжуулах ажлыг зохион байгуулах талаар санал боловсруулсан байна.	Суурь судалгааны мэдээллүүд болох хүрээлэн буй орчин, инженер геологи, газар хөдлөлт, гамшгийн мэдээллийн санг 11 суурь давхаргын нийт 75 сэдэвчилсэн тоон зургийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үүнээс Түүх, Археологийн дурсгалт газар, Тектоник, шинэ тектоник зэрэг суурь давхаргын мэдээллүүд нь шинэчлэх шаардлагагүй, шаардлага хангасан мэдээллүүд байна. Харин шинэчлэгдэх шаардлагатай давхаргуудаас газар хөдлөлийн бичил мужлалын Мөрөн, Даланзадгад сумын судалгааг Одон орон геофизикийн хүрээлэн хийж дуусгасан бөгөөд тус газраас холбогдох мэдээлэл, тайланг ирүүлсний дараа захиалагчийн хяналт хийж, Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд оруулна. Бусад суурь давхаргын мэдээллээс геологи, геоморфологи, гидрогеологи, инженер геологийн том	1-6

						масштабын зургууд аймаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн үе шатанд зориулсан инженер-геологийн судалгааны тайлангаас баяжуулах боломжтой талаар судалгаа хийсэн. Суурь мэдээллийн баяжуулалтыг хийхийн тулд аймаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн үе шатанд зориулсан инженер-геологийн судалгаа хийх ажлын даалгаварт тайлангийн тоон мэдээллийг Газрын мониторингийн хэлтэст хүлээлгэн өгч захиалагчийн хяналт хийлгэж байхаар санал боловсруулсан.		
Зорилт 4 “Улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх”								
10	Арга хэмжээ 4.1 Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх.	Холбогдох албан хаагчид	МУ-ын 3Г-ын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх журмыг шинэчлэн боловсруулж, тус арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийг тусгасан.	Тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгжтэй хамтран хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ. Үнэлгээний үр дүнд үндэслэн Суурь судалгаа мониторингийн асуудал хариуцсан албан хаагчдын үйл ажиллагааг сайжруулах сургалт зохион байгуулах.	Тус ажлын хүрээнд Санбарын улсын ерөнхий байцаагчийн 35-00/04 дугаартай удирдамж батлагдаж, Нийслэл дүүргүүдийн Газар зохион байгуулалтын албанд төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж, 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр газрын даргад танилцуулсан.	1-12 сар		
11	Арга хэмжээ 4.2	Шалгалт хийсэн		Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын төлөв байдал,	1-12		

	Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	объектын тоо		хийж, шалгалтын дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.	чанарын хянан баталгааны үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийг байгуулж, хамрагдах 20 хуулийн этгээдийг сонгосон. Хариуцан ажиллах 4 хуулийн этгээдийн 2024 онд хийсэн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны нийт 20 ажлын гүйцэтгэлийн чанарт хяналтыг хийж, нэгдсэн тайланг боловсруулсан.	
	Зорилт 5 “Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох”					
12	Арга хэмжээ 5.1 Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах	Мэдээлэл өгч, сурталчилсан ажлын тоо	-	Шинэчилэн батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны журам”-ыг танилцуулах, орон нутагт чиглэл хүргүүлэх, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан байна.	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журмын батлагдсан төслийг аймгийн мэргэжилтнүүдэд хүргүүлсэн. Журамд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар аймгийн мэргэжилтнүүдэд тайлбар мэдээллийг Говийн болон Зүүн бүсийн сургалтаар өгч ажилласан. Журмын өөрчлөлтийн танилцуулга хийж аймаг, нийслэлд хүргүүлэх ажлын хүрээнд хэвлэлийн зардлын тооцоог гаргаж ахлах мэргэжилтэн Г.Анхбаярт өгсөн. Журмын шинэчлэлт, өөрчлөлтийн талаар мэргэжлийн байгууллага, иргэд, аймаг, нийслэл, дүүргийн мэргэжилтэн нарт тухай бүр мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан. Журманд орсон өөрчлөлтийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт 1/1829 дугаартай албан бичгийг 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн.	1-12 сар
	Зорилт 6 “Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах”					

13	Арга хэмжээ 6.1 Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж, цахимаар болон хэвлэмэл байдлаар ирүүлсэн тайлан, хянаж, дүгнэлтийг баталгаажуулах	Захиалгат хянан баталгаа хийж, баталгаажсан тайлан, дүгнэлтийн тоо	2023 онд нийт 566 тайлан, дүгнэлт баталгаажуулсан	Цахимаар илгээсэн хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан байна	Цахимаар илгээсэн газрын төлөв, байдал чанарын захиалгат хянан баталгааны 82 тайланг хянаж, баталгаажуулсан, 23 тайлан хянаж буцаасан байна. Цаасаар ирүүлсэн газрын төлөв, байдал чанарын захиалгат хянан баталгааны 18 тайланг хянаж, баталгаажуулан хүргүүлсэн.	1-12 сар
14	Арга хэмжээ 6.2 Магадлан итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лабораторид хийгдсэн хөрсний задлан шинжилгээний хариуг Газрын мониторингийн цахим системд автоматаар оруулах ажлыг зохион байгуулах	Гэрээ байгуулсан итгэмжлэгдсэн лабораторийн тоо	Газрын мониторингийн цахим систем ажиллуулах журам батлагдсан. Лабораторийн эрхлэгчид олгох эрхийн модулийн тохиргоо хийгдсэн.	Итгэмжлэгдсэн лабораториудтай уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагааны гэрээ газрын мониторингийн системд нэмэлт хөгжүүлэлт хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Лабораторийн шинжилгээг газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайланд лаборатори оруулдаг байх хөгжүүлэлтийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Лабораториудад 2024 оны 04 дүгээр сарын 19, 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд сургалт хийсэн, мэргэжлийн байгууллагуудад нэмэлт хөгжүүлэлтийн талаар 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн сургалтанд мэдээллийг өгсөн. Итгэмжлэл нь хүчинтэй байгаа "Нарт ШУҮН консалтинг" ХХК, "Гацуурт" ХХК, "Грийн лаб" лаборатори, "Дээж" лаборатори, ХААИС-ийн лаборатори, "Инно хими" ХХК-ийн лабораторитой хамтран ажиллах гэрээг байгуулсан.	1-12 сар
					Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр 2024/220 дугаар гэрээ байгуулсан. "Нарт ШУҮН консалтинг" ХХК-ын итгэмжлэлийн хугацаа 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр дуусаж,	

						Газрын мониторингийн цахим системд эрхийг түр хаасан. Итгэмжлэлээ дахин баталгаажуулсан Инженер геодези лабораторитой 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр 2024/249 дугаартай гэрээ байгуулсан. "Ханлаб" хөрс, усны лабораторид 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Газрын мониторингийн цахим системд хандан ажиллах, хөрс, усны шинжилгээний үр дүнг оруулах талаар сургалт хийсэн. "Ханлаб" хөрс, усны лабораторитой 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 2024/321 дугаар гэрээ байгуулсан. Газрын мониторингийн цахим системд шинжилгээний үр дүн оруулах итгэмжлэгдсэн 8 лаборатори хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байна.	
Зорилт 7 "Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх"							
15	Арга хэмжээ 7.1 Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах	Үүрэг даалгаврын тоо	Жил бүр хийгддэг	Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна.	Удирдлагаас болон хурлаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэж, тухай бүр тайлагнасан.	1-12 сар	
16	Арга хэмжээ 7.2 Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх	Тушаалд заасан хугацаа	Жил бүр хийгддэг	Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна.	Газрын даргын тушаалаар батлагдсан А/02 ажлын хэсэгт ажиллаж, газрын даргын дэргэдэх хурлын танилцуулгад газрын төлөв байдал, чанарын хянан баталгаатай холбоотой танилцуулга, мэдээлэл, мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээ, лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээний хөлсний хэмжээ тогтооход санал гаргаж хүргүүлсэн.	1-12 сар	

230

						Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны 2024 онд хийгдсэн тоо хэмжээний мэдээллийг нэгтгэн гаргаж, ажлын хэсгийн даргад хүргүүлсэн.		
17	Арга хэмжээ 7.3 Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах холбогдох арга хэмжээг зохион байгуулах	Тогтоол, шийдвэрийн тоо	Жил бүр хийгддэг	Холбогдогох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна	-		1-12 сар	
18	Арга хэмжээ 7.4 Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, албан бичгийн тоо	Жил бүр хийгддэг	Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Тайлант хугацаанд ирсэн 73 албан бичгийг шийдвэрлэж, хариу хүргүүлсэн.		1-12 сар	
19	Арга хэмжээ 7.5 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Баримтын тоо	Жил бүр хийгддэг	Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна.	Урьд оны хийгдсэн ажлын баримт бичгийг архивлаж байгууллагын архивт хүлээлгэн өгсөн.		1-12 сар	

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Баруун бүсийн 5 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулах	-	Баруун бүсийн 5 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Баруун бүсийн 5 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 01 дүгээр сарын 28-наас 02 дугаар сарын 02-ны хооронд Увс аймгийн Улаангом суманд зохион байгуулсан.	1-2 сар	
2	"Хөрс, ус, агаар орчны судалгаа-GLOBE 2024" илтгэлийн уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн 9-12 ангийн	Илтгэлийн уралдааныг зохион байгуулах	-	"Хөрс, ус, агаар орчны судалгаа-GLOBE 2024" илтгэлийн уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн 9-12 ангийн	"Хөрс, ус, агаар орчны судалгаа - GLOBE 2024" илтгэлийн уралдааныг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн газар	1-2 сар	

	сурагчдын дунд зохион байгуулах			сурагчдын дунд зохион байгуулах	зохион байгуулалтын алба, Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам болон Олон улсын хөтөлбөрийн сургалттай нийслэлийн ерөнхий боловсролын "Шинэ Эхлэл" сургууль нар хамтран 02 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан.	
3	"2022 оны 22/265 тоот гэрээт ажлын баталгаат хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө"-г боловсруулах	Төлөвлөгөө боловсруулах	-	"2022 оны 22/265 тоот гэрээт ажлын баталгаат хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө"-г боловсруулах	"2022 оны 22/265 тоот гэрээт ажлын баталгаат хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө"-г боловсруулж, 02 дугаар сарын 21-ний өдөр батлуулсан.	1-2 сар
4	Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран ажиллах гэрээ боловсруулж батлуулах, мэргэжилтэнд эрх нээх тушаал боловсруулж батлуулах	Хамтран ажиллах гэрээ байгуулах	-	Хамтран ажиллах гэрээ, мэргэжилтэнд эрх нээх тушаал боловсруулж батлуулах	Нийслэлийн Байгаль орчны газартай хамтран ажиллах 2024/74 тоот гэрээг 03 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан. Хөрсний судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Саранзаяад Газрын мониторингийн цахим системийн дундын мэдээллийн санд хандах эрхийг нээх тушаалыг 03 дугаар сарын 22-ны өдөр гаргаж, эрх нээж өгсөн.	1-3 сар
5	"FASEP-MONGOLIA" төслийн явц үр дүнг танилцуулах сургалт, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	Уулзалт зохион байгуулах	-	Уулзалтыг зохион байгуулж, сургалтанд хамрагдсан байна.	03 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд "FASEP-MONGOLIA" төслийн явц үр дүнг танилцуулах сургалт, зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, сургалтад хамрагдсан.	2-3 сар
6.	Говийн бүсийн 5 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулах	-	Говийн бүсийн 5 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Говийн бүсийн 5 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 04 дүгээр сарын 09-нөөс 12-ны хооронд Дорноговь аймгийн Сайншанд суманд зохион байгуулсан.	4 сар
7.	Зүүн бүсийн 3 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулах	-	Зүүн бүсийн 3 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Зүүн бүсийн 3 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 05 дугаар сарын 14-нөөс 17-ны хооронд Дорнод аймгийн Чойбалсан суманд зохион байгуулсан.	5 сар
8.	21 аймгийн ГХБХБГ-ын суурь судалгаа мониторинг хариуцсан мэргэжилтэн,	Сургалт зохион байгуулах	-	21 аймаг, нийслэл, дүүргийн асуудал хариуцсан	21 аймгийн ГХБХБГ-ын суурь судалгаа мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Нийслэлийн Газар зохион	6 сар

	нийслэл дүүргийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн сургалт			мэргэжилтнүүдийг чадавхжуулах танхимын болон хээрийн хэмжилт хосолсон сургалт зохион байгуулах	байгуулалтын албаны Газар ашиглалт, мониторингийн хэлтсийн албан хаагчид, 9 дүүргийн ахлах мэргэжилтэн нарт 2024 оны 06 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд танхимын болон хээрийн хэмжилт судалгаа хосолсон сургалтыг зохион байгуулсан.	
--	---	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа
	1	2	3	4	5	6
1.	Арга хэмжээ 1. Удирдлагын академийн "Өгөгдлийн сан", "Өгөгдлийн график дүрслэл" цахим сургалт			Сургалтанд хамрагдаж төгссөн байна.	"Өгөгдлийн сан" цахим сургалтын 4 модуль хичээлийг үзэж, судалсан. "Өгөгдлийн график дүрслэл" цахим сургалтын 3 модуль хичээлийг үзэж судалсан.	1-6 сар
2.	Арга хэмжээ 2. Төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалт /Монгол бичиг/			Түвшин 1 Түвшин 2 Түвшин 3	Монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан.	6-12 сар
3	"Цаг агаарын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ" сэдэвт сургалт			Сургалтанд хамрагдаж төгссөн байна.	Гурван өдрийн танхимийн сургалтад 7 агуулгын хүрээнд газарзүйн мэдээллийн систем дээр боловсруулалт хийж, амжилттай дуусган гэрчилгээ авсан.	5 сар
4	"Шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих аргачлал боловсруулах нь" сэдэвт сургалт			Сургалтанд хамрагдаж төгссөн байна.	Сургалтын хөтөлбөрийн хүрээнд нийт 50 цагийн хичээл судалж 24/1515 дугаартай үнэмлэх авсан.	

ТАЙЛАН ГАРГАСАН:
Газрын мониторингийн хэлтсийн мэргэжилтэн



Г.Золзаая

2024.12.04

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ
ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: Г.Золзаяа
Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 11 сарын 13 өдөр
Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай	Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар
Зорилт 1. Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх.			
1.	Арга хэмжээ 1.1. Газрын мониторингийн цахим системд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтэд тусгагддаг газрыг хамгаалах, зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр холбогдох хууль, журамд тодорхой заасан заалт болон нийтлэг зөвлөмж, арга хэмжээний загварыг жагсаалтаар бэлтгэж, системээс автоматаар сонгогдох боломжийг бүрдүүлэх	-	-Бэлтгэсэн загварыг оруулах талаар Софт мастер ХХК-д хэлж оруулах
2.	Арга хэмжээ 1.2 Улсын тусгай хэрэгцээ, ойн сан бүхий, усны сан бүхий газрын мониторингийн цэгийн байршил, байнгын ажиглалтын талбаруудын төлөөлөх талбайн хэмжээ, байршлыг нарийвчлан зураглах талаар санал боловсруулах	-	-
Зорилт 2. Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих.			


3.	Арга хэмжээ 2.1. Ойн сан бүхий болон усны сан бүхий газрын хамгаалалт, эрүүл ахуй, хориглолтын бүсийг холбогдох байгууллагуудтай хамтран зураглах, газрын мониторингийн цахим системийн дундын мэдээллийн сантай холбох.	-	-	-Ойн газарт албан бичиг хүргүүлэх
4.	Арга хэмжээ 2.2. Улсын хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөгөөт хянан баталгааны ажил болон захиалгат хянан баталгааны ажлын үр дүн, мэдээллийг нэгтгэж, газрын мониторингийн цахим системд нөхөж оруулах.	-	-	-
Зорилт 3. Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг нэвтрүүлэх.				
5.	Арга хэмжээ 3.1. Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох.	-	-	- 12 дугаар сарын 01-ний дотор нэгдсэн тайлан гаргах /Ахлах мэргэжилтэн Г.Анхбаярт хариуцсан аймгуудын тайланг нэгтгэж өгөх/
6.	Арга хэмжээ 3.2. Газрын мониторингийн цахим системд зайнаас тандан судлал, доройтлыг тодорхойлох зураглалыг үүсгэх шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийх	-	-	-Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, турших
7.	Арга хэмжээ 3.3. Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, салбар хоорондын мэдээллийг холбох ажлыг зохион байгуулах	-	-	-Дундын мэдээллийн санг ажиллагаанд оруулах
8.	Арга хэмжээ 3.4. Газрын мониторингийн цахим системийн хялбарчилсан цахим гарын авлага гаргах.	-	-	-12 дугаар сарын 05-ны дотор гарын авлагыг боловсруулсан байх
9.	Арга хэмжээ 3.5. Газрын мониторингийн суурь мэдээлэл болох хүрээлэн буй орчин, инженер геологи, газар хөдлөлт, гамшгийн	-	-	-Саналыг сайжруулах

	мэдээллийн санг баяжуулах талаар санал боловсруулах		
Зорилт 4. Улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх.			
10.	Арга хэмжээ 4.1. Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх.	-	
11.	Арга хэмжээ 4.2. Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх		-Хяналт шалгалтын ажлыг хийж дуусгах
Зорилт 5. Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох.			
12.	Арга хэмжээ 5.1. Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах	-	
Зорилт 6. Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах.			
13.	Арга хэмжээ 6.1. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж, цахимаар болон хэвлэмэл байдлаар ирүүлсэн тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах	-	
14.	Арга хэмжээ 6.2. Магадлан итгэмжлэгдсэн хөрсний хяналт, шинжилгээний лабораторид хийгдсэн хөрсний задлан шинжилгээний хариуг Газрын мониторингийн цахим системд автоматаар оруулах ажлыг зохион байгуулах	-	
Зорилт 7. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх			
15.	Арга хэмжээ 7.1.	-	
16.	Арга хэмжээ 7.2.	-	
17.	Арга хэмжээ 7.3.	-	

18	Арга хэмжээ 7.4.	-	-	-
19.	Арга хэмжээ 7.5.	-		

ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:

**ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА**

 /Б.ДӨЛ/